# ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Л.ОТГОНБААТАРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Үр дүнгийн үзүүлэлт | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 9 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан 1 дүрэм, 20 журам, 11 тогтоол, тушаал, шийдвэр, 29 заавар, зөвлөмж, аргачлал, чиглэл, 17 тайлбар, судалгаа мэдээлэл ирүүлсэн бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | |
| ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ | | | | | | | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.7 | А. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөр, зөрчлийн өмнөх оны хуримтлагдсан авлагыг барагдуулах. Үүнд: **1. Мөнгөн болдог ХХК-2398937.00 алдангийн авлага** **2. ОХУ-ын Дорнод Сибирийн ТУИС-ийн УБ салбар-602546.42 алдангийн авлага** **3. Өргөө хаан констракшн ХХК акт-1073913.00** | Төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан байна. | Мөнгөн болдог ХХК-ны 2,398,9 сая төгрөг бүрэн барагдсан.ОХУ-ын Дорнод Сибирийн ТУИС-ийн УБ салбарын 602546 төгрөг хүчингүй болгох Өргөө хаан констракшн ххк-ны 1073,9 сая төгрөг бүрэн барагдах | 2024 оны эхний хагас жилд 50-аас доошгүй хувийг бууруулсан байна | Дээрхи ажлын хүрээнд Мөнгөн болдог ХХК нь 2024 онд нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо хийгээгүй хаяг байршил дээрээ байхгүй утас нь холбогдохгүй одоог хүртэл төлбөрөө төлөөгүй тул 2024 оны 05 сард Шүүхийн төрөлжсөн архивт хандан лавлагаа гаргуулан авч Шүүхийн байгууллагад шилжүүлсэн.<br>Оросын Холбооны Улсын Дорнод Сибирийн Технологи Удирдлагын Их Сургуулийн алдангийн өрийг барагдуулахаар Улсын бүртгэлийн газар, БЗД-ийн Татварын хэлтэс болон Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яамруу албан тоотууд явуулж улмаар тус яамны 2022-04-07-ны 6/1592 тоот албан бичгээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь хүчингүй болсон тухай хариу бичгийг авч НДЕГ-ын Хяналт Шалгалтын Газарт хүргүүлж алдангийг хүчингүй болгуулахаар ажиллаж байна.2024 онд Улсын ерөнхий байцаагч томилогдвол шийдвэрийг танилцуулах талаар хариу ирүүлсэн болно.<br>Өргөө хаан констракшн ХХК-ны 1073913.00 төгрөгний өр бүрэн барагдсан. | 2024.01.01<br>2024.12.31 | |

<table>
<tr>
<td></td>
<td>Б.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөр, зөрчлийн өмнөх оны хуримтлагдсан тэтгэврийн авлагыг барагдуулах.</td>
<td>Төлбөр зөрчлийг бүрэн барагдуул-сан байна.</td>
<td>Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөр, зөрчлийн өмнөх оны хуримтлагдсан тэтгэврийн авлагын 138,8 сая төгрөгнөөс 20 хувь буюу 27,7 сая төгрөг бүрэн барагдана.</td>
<td>2024 оны эхний хагас жилд 50-аас доошгүй хувийг бууруулсан байна</td>
<td>
<table>
<tr><th>Нэр</th><th>Эхний үлдэгдэл</th><th>Барагдалт</th><th>Үлдэгдэл</th></tr>
<tr><td>С.Амар-баясгалан</td><td>6432429</td><td>3090000</td><td>4422429</td></tr>
<tr><td>Д.Баярмаа</td><td>22478967</td><td>1080000</td><td>21398967</td></tr>
<tr><td>Р.Батсайхан</td><td>5699786</td><td>5699786</td><td>0</td></tr>
<tr><td>М.Дуламсүрэн</td><td>14325342</td><td>5100000</td><td>9225342</td></tr>
<tr><td>Х.Энхбаяр</td><td>200000</td><td>200000</td><td>0</td></tr>
<tr><td>Ш.Энхбаяр</td><td>216000</td><td>216000</td><td>0</td></tr>
<tr><td>Д.Должинсүрэн</td><td>13539000</td><td>3090000</td><td>10449000</td></tr>
<tr><td>Ц.Зоригтбаатар</td><td>18759753</td><td>5646857</td><td>13112896</td></tr>
<tr><td>Д.Баатарсүрэн</td><td>26144903</td><td>5741082</td><td>20403821</td></tr>
<tr><td>Л.Сэргэлэн</td><td>14994203</td><td>3090000</td><td>11904203</td></tr>
<tr><td>А.Нарантуяа</td><td>16055027</td><td>3750000</td><td>12305027</td></tr>
<tr><td></td><td>138845410</td><td>36287725</td><td>103221685</td></tr>
</table>
НДЕГ-ын хяналт шалгалтаар 13 иргэнтэй холбоотой 251,6 сая төгрөгний төлбөр зөрчил илрүүлсэн бөгөөд 2024 онд зөрчилтэй иргэдийг дахин хуваарилан одоогоор 11 иргэнтэй холбоотой 138,8 сая төгрөгний төлбөр зөрчил барагдуулахаар ажиллаж байна. Оны эхнээс нийгмийн даатгалын шинэ хууль батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шинэчилсэн программ хангамжийн асуудал бүрэн шийдэгдээгүйгээс зарим суутгалтай иргэдийн тэтгэврийн суутгал буруу орох тохиолдолууд гарсан болно. Дээрхи 11 иргэнээс 3 иргэний төлбөр бүрэн барагдаж үлдсэн 8 иргэн тэтгэврээсээ 50 хувийн суутгал хийлгэж байна. 2024 онд 36,3 сая төгрөг барагдаж барагдалт 30 хувьтай явж байна.
</td>
<td>2024.01.01<br>2024.12.31</td>
<td></td>
</tr>
<tr>
<td></td>
<td>В. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актаар тогтоосон төлбөр, зөрчлийн өмнөх оны</td>
<td>Төлбөр зөрчлийг бүрэн барагдуул-сан байна.</td>
<td>Нийт 3044806.00 төгрөг барагдах</td>
<td>2024 оны эхний хагас жилд 30-аас доошгүй хувийг бууруулсан байна</td>
<td>Ажилгүйдлийн даатгалын сангаас илүү авсан нэр бүхий 2 иргэнтэй холбоотой илүү авсан тэтгэмжийг барагдуулахаар ажиллаж байна.<br>1. М.Баатархүү ОЮ75051817</td>
<td></td>
<td></td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуримтлагдсан ажилгүйдлийн тэтгэмжийн авлагыг барагдуулах. | | | | 2.Ш. Бүрэнтөгс ИА82022112<br>Нийт авлага-3044806.00 төгрөг барагдуулна.Хэсгийн ахлагчтай холбогдож утасны дугаар олж өгөхөөр тохиролцсон.М.Баатархүү нь /авлага-708741.00/ Зорчигч тээвэр-3 компанид ажилладаг бөгөөд СБД-ийн НДХ-ийн байцаагчаар иргэнтэй холбогдох талаар арга хэмжээ авч ажилласны үр дүнд 650000 төгрөг төлүүлж үлдэгдэл 58741 төгрөгийг 12 сардаа багтаан төлнө.<br>Иргэн Ш.Бүрэнтөгс нь /авлага-2336065.00/Тэргүүн саруул зам ХХК-д ажилладаг бөгөөд нябо-той нь холбогдсон.<br>**Нийт барагдалт-50 хувь** | 2024.01.01<br>2024.12.31 | |
| **ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг веб сайт хуудсанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг бүрэн (100%) хангасан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 5 дугаар сарын 01-ны “Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын талаарх зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн хүрээнд цахим хуудсанд мэдээлэл байршуулалтанд анхаарч Нийтийн мэдэллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.Дээрхи ажлын хүрээнд ирүүлсэн зөвлөмжийг дагаж мөрдөн ЗГ-ын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох үнэлгээ хийх журам”-ын дагуу ажлын үр дүнг тооцон ажиллаа. | 2024.01.01<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | | | | | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | *Нийгмийн даатгалын сан нийт 183 / Төсвийн гүйцэтгэл-71, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт-39, Бусад-73/ мэдээллийг оруулсан ба хугацаа хоцроож оруулсан 2 мэдээлэл байна. Хугацаандаа байршуулсан мэдээлэл 98.9% хувьтай байна.<br>*Нийгмийн даатгалын байгууллагын санхүү нийт 183 / Төсвийн гүйцэтгэл-71, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт-39, Бусад-73/ мэдээллийг оруулсан ба хугацаа хоцроож оруулсан 1 мэдээлэл байна. Хугацаандаа байршуулсан мэдээлэл 99.4% хувьтай байна | 2024.01.01 2024.12.31 | |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон Газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл | Шалгалтын удирдамж батлуулан шалгах ААНБ-ын нэрсийг батлуулан хяналт шалгалтыг эхлүүлэх. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулж илэрсэн зөрчлийн 80-аас доошгүй хувийн барагдуулж | 1.Хэлтсийн даргын 2024 оны 1 дүгээр сарын 08-ны **01** тоот удирдамжийн хүрээнд Монгол Улсын "Нийгмийн даатгалын тухай" хууль, "Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм" түүнийг хэрэгжүүлэх, ажил олгогч даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах, хянах баталгаажуулах журмын хэрэгжилтийг 2023 оны 01 дүгээр сарын 01- | 2024.01.01 2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгж, байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | хувийг хамруулна. | | ажилласан байна. | нээс 2023 оны 12 дугаар сарын 31-ныг дуустал хугацааг хамруулан шалгаж, аливаа зөрчил, ажлын дутагдал доголдлыг таслан зогсоох, засаж залруулах, урьдчилан сэргийлэх, нийгмийн даатгалын ажилтны vvрэг хариуцлагыг өндөржvvлэх, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдний нийгмийн баталгааг найдвартай хангах зорилгоор холбогдох арга хэмжээ авч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах зорилгоор Орлого шимтгэлийн байцаагч Наранцэцэг, Алтанцог нарын хариуцан ажилладаг **1563** аж ахуйн нэгж байгууллагын тайланг шалгав.<br><br>2.Программын шинэчлэлтэй холбоотойгоор тухайн удирдамжинд заагдсан хяналт шалгалтыг хийх гүйцэтгэх боломжгүй болсон байна. | | |
| | 2023 оны шинээр тэтгэвэр тогтоосон байдал болон тэтгэврийн олголтод хяналт шалгалт хийх. | 2023 оны тэтгэврийн тогтоолт /648 иргэн/ олголтод шалгалт хийж, илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах арга хэмжээ авах. | Илэрсэн төлбөр зөрчлийн 80-аас доошгүй хувийг бүрэн барагдуулсан байна. | Тэтгэврийн олголтоор гарсан зөрчлийн 80 хувийг бүрэн барагдуулах | 3.Удирдамжийн хавсралтанд заагдсан нийт 3876 иргэний шинээр тэтгэвэр тогтоолтонд 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийг дуустал хугацаанд "Нийгмийн даатгалын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, нийгмийн даатгалын хяналт шалгалтын нэгдсэн журам, зааврын хүрээнд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.<br><br>4.Шалгалтаар:<br><br>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тогтоогдсон тэтгэврийн 2023 оны шинэ тогтоолтод хяналт, шалгалт хийх /хавсралт-1/ чиглэлийн дагуу шалгалтыг явууллаа. | 2024.01.01<br>2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шалгалтанд: 648 иргэний хувийн хэрэг шалгуулахаар массиваар гарсан бөгөөд одоогийн байдлаар 26 хувийн шалгах дутуу байгаа болно. Дээрхи шалгуулаагүй хувийн хэргүүдийг шалгуулах үүргийг хороо хариуцсан байцаагчид өгч дахин шалгалаа.<br>Үүний үр дүнд 2 иргэнтэй холбоотой илүү олгосон 24735 төгрөгийг суутгаж дутуу олгосон 26400 төгрөгийг Улсын байцаагчийн актаар нөхөж олголоо.<br>Тодруулах шаардлагатай 23 иргэний жагсаалтыг хүргүүлэн шалтгааныг тодруууллаа.Зөрчил 100 хувь барагдсан. | | |
| | Орлого шимтгэлийн байцаагч П.Наранцэцэг болон Г.Алтанцог нарын хариуцсан байгууллагуудын 2023 оны тайлан авсан байдалд хяналт шалгалт хийх | 1563 ААНБ-ын тайлан авсан байдлыг шалгах | Тайлан өгсөн ААНБ бүрэн хамрагдах | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, Газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулж илэрсэн зөрчлийн 80-аас доошгүй хувийн барагдуулж ажилласан байна. | 5.Шалгалтаар:<br>- Ажил олгогч байгууллагын тамга, тэмдэг дарж баталгаажаагүй 3 зөрчил бүртгэгдсэн алдаа залруулсан.<br>-Ажил олгогч байгууллагын удирдлагын гарын үсэг зурагдаагүй баталгаажаагүй, зөрчил бүртгэгдээгүй.<br>- Шимтгэл төлөлтийн тайлан /НД-7, НД-8/ мэдээллийн сантай шимтгэлийн үлдэгдэл зөрүүтэй байгууллага бүртгэгдсэнгүй.<br>- Шимтгэл төлөлтийн тайлан /НД-7, НД-8/-г тайланг цахимаар авч мэдээлэлд оруулсан боловч **614** байгууллагын цаасан тайлан ирүүлээгүй зөрчил гарсан.<br>- Шимтгэл төлөлтийн тайлангийн төрөл буруу хүлээн авч давхардсан тоогоор 53 даатгуулагчийн төрөл буруу жагсаалтыг Орлого шимтгэлийн тасагт хүргүүлэн зөрчлийг арилгаж ажиллах талаар заавар зөвлөгөө өгч ажиллаж байна<br>- Нийгмийн даатгалын тайланг хүлээж авахдаа тайлангийн тоон үзүүлэлт болон тайлангийн он сар зассан зөрчил илрээгүй.<br>-Тайлант хугацаанд 77 аж ахуйн нэгж | 2024.01.01<br>2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагын тайланд залруулга хийсэн байна.<br>-Хариуцлага тооцоогүй 217 аж ахуйн нэгж байгууллага нь тухайн онд данс хаах болон албан шаардлага хүргүүлсэн зэрэг ямар арга хэмжээ авсан талаар байцаагчаас тодруулан цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөлдөж байна.<br>Шимтгэлийн авлага өссөн цаашид хэрхэх талаар ямар нэгэн хариуцлага тооцоогүй байгууллагуудыг хамруулсан болно.<br>Байцаагч Алтанцогийн хариуцсан ААНБ-с төрлийн код буруу шивэгдсэн 3 ААНБ-тай хамааралтай 11 иргэний мэдээлэл, байцаагч Наранцэцэгийн хариуцсан 17 ААНБ-тай хамааралтай 42 иргэний мэдээллийг засаж улсын байцаагчийн актаар хариуцлага тооцох шаардлагатай байна.<br>Мөн доод хэмжээнээс төлдөг болон 1 даатгуулагчтай ААНБ-ын судалгааг гаргаж өгсөн болно.<br>Шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авах баталгаажуулах журмын хүрээнд 90 хоногийн доторх нөхөн тайланг Орлого шимтгэлийн тасгийн байцаагч нар хүлээн авч шийдвэрлэхдээ анхан шатны баримтын бүрдлийг бүрэн гүйцэт шалгаж авч шийдвэрлэх, шимтгэл төлөлтийн хувь хэмжээг зөв тооцсон эсэх, Зөрчлийн тухай хуулийг зөв хэрэглэсэн эсэх гарсан зөрчлийг залруулж цаашид энэхүү зөрчлийг давтан гаргахгүй байх илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах талаар анхааруулж ажиллалаа.<br>ОШТасгийн байцаагч нар хуулийн дагуу хариуцлага тооцож Нийгмийн даатгалын шимтгэл болон төлбөр зөрчлийг төлүүлэн ажилласан байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тайланд хугацаанд байцаагч нараас авсан арга хэмжээний талаар<br><br>Байцаагч Наранцэцэгийн хувьд:<br><br>90 хоногоос дээш нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 219 ААНБ-ын 2,4 тэрбум төгрөгний авлагатай. Үүнээс өнгөрсөн онд 194 ААНБ-тай уулзалт зохион байгуулсан. 155 ААНБ-д албан шаардлага хүргүүлсэн. 156 ААНБ-тай өр барагдуулах гэрээ байгуулсан. 502 ААНБ-ын харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоосон. 2 ААНБ/ Арвижих ням ХХК-24,3 сая, Жи пи эс ти ХХК-89,6 сая/ -ыг өрийг барагдуулахаар Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.<br><br>Байцаагч Алтанцогийн хувьд:<br><br>90 хоногоос дээш нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 288 ААНБ-ын 6,7 тэрбум төгрөгний авлагатай. Үүнээс өнгөрсөн онд 70 ААНБ-тай уулзалт зохион байгуулсан. 115 ААНБ-д албан шаардлага хүргүүлсэн. 69 ААНБ-тай өр барагдуулах гэрээ байгуулсан. 396 ААНБ-ын харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоосон.<br><br>Хэлтсийн хэмжээнд болон шалгасан байцаагчийн хүрээнд харахад цаг үеийн байдал болон шинээр мөрдөж байгаа дүрэм журмын хүрээнд тайланг цаасан хэлбэрээр авах ажиллагаа хялбарчлагдаж жилд 2 удаа авах хэлбэрт шилжсэн гэх давуу талтай болж байцаагч нарын ажил хөнгөвчлөгдөж байгаа хэдий ч 1563 ААНБ-с тоон гарын үсгээр 200 ААНБ буюу 12,7 хувь үлдсэн 1363 ААНБ-ын 614 ААНБ буюу 45 хувь нь ямар нэгэн байдлаар тайлангаа өгөөгүй гэдэг үзүүлэлт гарч байна. Үүнээс үзэхэд бид хагас жилийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байдлаар цаасан тайлан авалт ядаж 90 хувь хүрэх болов уу гэсэн төсөөлөлтэй байсан ба сэтгэлд хүрсэнгүй . Учрыг байцаагч нараас лавлахад бараг орчин үед техник технологи хөгжсөн цаг үед тайланг цаасаар нэхэхэд загнуулдаг гэсэн хариу өгсөн бөгөөд улс орны хөгжил цэцэглэлт байгаа байдал мөрдөж байгаа журам дүрмэндээ захирагдан тайлангаа авах нь зүйтэй гэж үзэж байна. | | |
| | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтныг томилж тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох, | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 90-ээс доошгүй хувиар барагдуулсан байна. | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн хүрээнд бүртгэл хөтлөн, хуулийн дагуу хариуцлага тооцож Нийгмийн даатгалын шимтгэл болон төлбөр зөрчлийг төлүүлэн ажилласан байна.Дээрхи ажлын хүрээнд 4 аж ахуйн нэгж байгууллагаас материал хүлээн авч 4 аж ахуйн нэгж байгууллагын материалыг хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэж 22,1 сая төгрөгний нийгмийн даатгалын шимтгэл, **1.0 сая** төгрөгний торгууль ногдуулан 100 хувь барагдуулан ажиллаа. | 2024.01.01<br>2024.12.30 | |
| | Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийх | Жилд 2 удаа тэтгэвэр авагчдын нийт тоогоор | Хуваарийн дагуу тоологдох ёстой хувийн хэргүүд бүрэн хамрагдсан байна. | Нийт тэтгэвэр авагчид бүрэн хамрагдана. | 6.Хяналт, шалгалтын улсын байцаагч Л.Отгонбаатар удирдаж байцаагч Д.Саранчимэг, М.Алтанхүү нарын бүрэлдэхүүнтэй 7,16,24 дүгээр хороодын массиваар бүртгэгдсэн нийт 5286 тэтгэвэр авагчдын хувийн хэрэгт тооллого хийлээ. Шалгалтыг 2024 оны 05 дугээр сарын 13-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 17-ний өдрийг дуустал хугацаанд "Нийгмийн даатгалын ерөнхий хууль" болон холбогдох | 2024.01.01<br>2024.12.30 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүрэм, журмын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Тооллогоор олдоогүй 5 иргэний хувийн хэргийг олж тооллогод хамруулах ажлыг зохион байгуулан ажилласны үр дүнд хувийн хэргийг олж 100 хувь тооллогонд хамрагдлаа. | | |
| | 2023 онд олгогдсон нийт тэтгэвэр олголтыг хянах ажлын удирдамж-06 | Хуваарийн дагуу тэтгэвэр олгосон иргэдийн тоогоор | Хуваарийн дагуу олголт шалгагдах ёстой тэтгэвэр авагчидын тоо бүрэн хамрагдсан байна. | Нийт тэтгэвэр авагчид бүрэн хамрагдана. | 7.Удирдамжийн хавсралтанд заагдсан 12, 13,14,16,17 хороодын нийт 10252 иргэний тэтгэвэр олголтонд 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ны өдрийг дуустал хугацаанд "Нийгмийн даатгалын тухай хууль" болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журам, нийгмийн даатгалын хяналт шалгалтын нэгдсэн журам, зааврын хүрээнд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.<br><br>Шалгалтаар:<br><br>Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу тогтоогдсон тэтгэврийн 2023 оны олголтыг хэсэгчилсэн байдлаар/ нас барсан, зогсоогдсон, шилжиж ирсэн, шилжиж явсан/ шалгалтыг явууллаа.<br><br>Шалгалтаар 2023 онд зогсоогдсон тэтгэвэр авагчдын олголтыг шалгах явцад нэр бүхий 24 иргэнтэй холбоотой шалгаж тодруулах шаардлагатай олголтыг холбогдох байцаагч нарт хүргүүлэн шалтгааныг тодруулж тахир дутуугийн хоногийн тэтгэврийг тооцож олгоогүй 0,8 сая төгрөгийн дутуу олголт олгосон байна. Төлбөр зөрчил 100 хувь барагдсан байна. | 2024.05.01<br>2024.07.30 | |
| | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуй нэгж байгууллагад хуулийн хэрэгжилтийг | | | | 8. 2024 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн 04 тоот төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удидамжаар Хонгор кэй жи ХХК /РД:6346065/-ны 2018-2023 онуудад олгосон хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогод ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу төлж, шимтгэл төлж ажилласан байдал, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шалгах ажлын төлөвлөгөөт бус удирдамж | | | | хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийлээ.<br>Тус компани нь 2018 оны 08 дугаар сарын 29-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Компаний үүсгэн байгуулагч хувьцаа эзэмшигч нь<br>1. Кэй жи ай эм ХХК /6329977/ эзэмших хувь-51<br>2. Хонгорын хүдэр ХХК /3129799/ эзэмших хувь-49<br>Хөрөнгөөр үүсгэн байгуулагдаж 2018 оны 9 дүгээр сараас эхлэн нийгмийн даатгалын шимтгэл төлж тайлан гаргаж эхэлсэн байна. Гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар улсын бүртгэлд бүртгүүлсэн.<br>Компани нь дүрмэндээ заасан эрх үүргийн хүрээнд хуулийн дагуу нийгмийн даатгал болон татварын тайлан гаргаж ирсэн.<br>2018-2023 оны санхүүгийн тайлангаас харахад:<br>Компани нь дээрхи онуудад ямар нэгэн борлуулалтын орлогогүй, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдаас өгсөн хөрөнгөөр ерөнхий ба удирдлагын болон бусад зардал гаргасан.Тухайн онуудын тайлангаа Баян ташаагийн эх аудитын компаниар баталгаажуулсан.<br>Тус компаниас ирүүлсэн 2024 оны 2 дугаар сарын 21-ны 2024/1 тоот албан хүсэлтийн дагуу Газрын даргын баталсан удирдажийн дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Тухайн компани нь мэргэжлийн баг хамт олон дутмаг, цаашид үйл ажиллагаа явуулах хууль эрхзүйг тодорхойгүй байдлаас болж татан буулгах шийдвэр гаргасан байна.Хүсэлтийн дагуу хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэхэд компаний санхүүгийн баримт бичиг стандартын дагуу бүрэн хөтлөгдсөн, нийгмийн даатгалын хуулийн дагуу тайлан мэдээг цаг тухайд нь гаргаж шимтгэл төлсөн ,шимтгэлийн өр төлбөргүй байна.<br>Нийгмийн Даатгалын Ерөнхий Газрын | 2024.01.01<br>2024.06.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Дотоод Аудит Мониторингийн Газарт нэр бүхий иргэнээс ирүүлсэн мэдээллийн дагуу БЗД-ийн Нийгмийн Даатгалын Газрын Хяналт Шалгалт Дотоод Аудитын тасгийн 01 тоот томилолтоор тус компанийн 2023 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланд нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийлээ. Шалгалтын явцад компани нь "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг 1,8 хувиар төлөх монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 17 дугаар тогтоолыг зөрчсөн зөрчил илэрлээ. Зөрчлийг арилгуулан Улсын байцаагчийн актаар дутуу төлөгдсөн шимтгэл, алданги **19,1** сая төгрөгийг нөхөн төлүүлж ажиллаа. | | |
| | Хуримтлагдсан өртэй аж ахуйн нэгж байгууллагуудад 2023 оны 06 тоот удирдамжийн хүрээнд хийгдсэн хяналт шалгалтын үр дүнд гүйцэтгэлийн болон төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэх ажлын хүрээнд | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг нийт аж ахуйн нэгж байгууллагын 20 хүртэл хувьд мөн нийгмийн даатгалын 2-3 сангийн зарцуулалтад дотоодын хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж | Хэлтсийн даргын баталсан 8 удирдамжийн хүрээнд 570 аж, ахуйн нэгж, 2928 иргэд даатгуулагчтай холбоотой хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулж илэрсэн зөрчлийн 80-аас доошгүй хувийн барагдуулж ажилласан байна. | Удирдамжийн дагуу 18-н байгууллагын 2022-2024 оны хагас жилийн санхүү болон бусад холбогдох баримтыг шалгахаас 6 аж ахуйн нэгж байгууллагын баримтыг шалгаж Зөвлөмж, Өр барагдуулах гэрээ байгуулсан, ШШГА-нд шилжүүлсэн-1, холбоо бариад ирэхгүй байгаа -11 .<br>2023 онд хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмж, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, хуримтлагдсан өр авлагын барагдуулах талаар уулзалт зохион байгуулж 1 аж ахуй нэгжийн өр 100 хувь бүрэн барагдуулахаар гэрээ хийсэн. Мөн 2 ААНБ-ын **1,1 тэрбум** төгрөгийн өр төлбөрийг бүрэн барагдуулсан. Бусад байгууллагын шалгалтын ажил үргэлжилж байна.. | 2024.08.01<br>2024.12.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллана | | | | | |
| 3.2.2. | БХЯ, ЗХЖШ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 1995 оноос хойш цэргийн алба хаасан нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй цэргийн албан хаагч нарын мэдээллийг санд бүрэн оруулах | ЗХЖШ-аас ирүүлсэн 10000 цэргийн мэдээллийг нэг бүрчлэн тулгаж мэдээллийн баазад оруулах | ЗХЖШ-аас ирүүлсэн 10000 цэргийн мэдээллийг нэг бүрчлэн тулгаж мэдээллийн баазад оруулсан байна. | Боломжит бүх хувилбараар мэдээллийг шүүж бүрэн хамруулах ажлыг зохион байгуулна. | Эхний ээлжинд регистрийн дугаар зөрчилтэй 100 цэргийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн баазаас эрэн хайх улсын бүртгэлээс лавлан тодруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг хагас, бүтэн жилээр гаргаж 2024 оны 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдөөр тасалбар болгон БХГ-т тайлагнаж 5000 цэргийн бүртгэлийг мэдээллийн санд бүртгэлээ. | 2024.01.01 2024.12.30 | |
| 3.2.5. | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулах, НДЕГ, ННДГ болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд | Дотоодын хяналт шалгалт болон Нийгмийн даатгалын ерөнхий газар, хөндлөнгийн хяналт шалгалтаар илэрсэн төлбөр зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг 2024 оны 06 дугаар сарын 20, 11 дугаар сарын | Газрын даргын баталсан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийт батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. | Хагас жил болон жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан байна. | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд дээд газарт хүргүүлэн ажилласан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газарт дээд газар болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын 6 мэдээ, судалгааг тогтоосон хугацаанд үнэн зөв гаргаж хүргүүлсэн. | 2024.01.01 2024.12.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх, | 20-ны өдрийн дотор ХШГ-т хүргүүлнэ. | | | | | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд дээд газраас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд засгийн газрын тогтоол-3, тушаал,шийдвэр -20, чиглэл зөвлөмж-1, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлт-1 нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн. | | *Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024.10.03-ны өдрийн "Аж ахуйн нэгж байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж<br>*2024.05.29-ны өдрийн "Дотоод хяналт шалгалтыг сайжруулах тухай" Дээд газраас ирсэн чиглэл дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, салбар, төлөөлөгчийн газар, төлөөний газарт хамаарах 6 аж ахуйн нэгж байгууллагад санхүү, татварын баримтад хяналт шалгалтын ажлыг явуулж зөвлөмж өгч, хугацаанд нь хүргүүлэн ажилласан.<br>*Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2024 оны Уул уурхайн бүтээгдэхүүн олборлогч, тээвэрлэгч зарим аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн хүрээнд 13 аж ахуйн нэгж байгууллагад шалгалт хийхээр төлөвлөгдсөн. Үүнээс 7 аж ахуйн нэгж байгууллагад баримтын шалгалт явуулсан, 1 аж ахуйн нэгж байгууллага нь татварт шалгагдаж байгаа тухай бичиг хүлээн авсан, бусад аж ахуйн нэгж байгууллагатай холбогдож хяналт шалгалт хийх тухай мэдэгсэн боловч холбогдох баримт, материал ирээгүй болно. | 2024.10.01<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | Иргэд, аж ахуй байгууллагаас ирсэн санал-3, өргөдөл-198, гомдол-5, хүсэлт-604 нийт 810 асуудлыг шийдвэрлэж , хэрэгжилт 90 хувьтай хэрэгжсэн. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлын тоогоор хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэж, илэрсэн зөрчлийг **80-аас** доошгүй хувь барагдуулж, тайлан, мэдээг үнэн гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлсэн байна | 2024 онд аж ахуйн нэгж байгууллага иргэдээс ирүүлсэн албан хүсэлт, өргөдлийг үндэслэн нийлбэр дүнгээр **35** аж ахуйн нэгж байгууллагыг нэг бүрчлэн шалгалаа.Шалгалтаар **35** аж ахуйн нэгж байгууллагын 1,5 тэрбум төгрөгний цалингийн санд ногдох **25.6 сая** төгрөгний дутуу тооцсон шимтгэлийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт үйлдэж түүнд ногдох алдангид **8.2** төгрөгийг ноогдуулсан байна. Нийт **33.8 сая** төгрөг төвлөрүүлэхээс төлбөр зөрчлийг бүрэн барагдууллаа. Мөн Үйлчилгээний тасгийн дутуу олгосон нэр бүхий 2 иргэнтэй холбоотой **2,6** сая төгрөгний ажилгүйдлийн тэтгэмжийг нөхөн олгохоор Улсын байцаагчийн акт үйлдлээ.<br><br>2024 оны байдлаар<br>Өргөдөл, гомдол-**22**<br>Албан бичиг-**45**<br>Нийт-**67** шийдвэрлэлт-100 хувь /Шийдвэрлэсэн байдлыг хавсаргав/<br><br>Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцож улсын байцаагчийн актаар 35 ААНБ-д хариуцлага тооцож 25,6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 8,2 сая төгрөгийн алданги нийт 33,8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг нийгмийн даатгалын санд төлүүлж ажилласан байна.<br><br>Зөрчлийн тухай хуулийн дагуу **4** ААНБ-д торгуулийн арга хэмжээ авч зөрчлийн хугацаанд нь барагдуулж ажилласан байна. | | |
| 4.1.7. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс | Авлигаас урьдчилан сэргийлэх | Газрын ажилтнуудад авлигын тухай, | Газрын албан хааг авлига, гэмт хэр зөрчлөөс урьдчил сэргийлэх ёс зүйн гэ | *2024.01.19-ны өдөр Авилгатай тэмцэх газраас Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хэрхэн зөв мэдүүлэх талаарх сургалт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | урьдчилан сэргийлэх | сургалт зохион байгуулсан байна. | нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалтанд хамрагдсан байна. | бүрэн хийгдсэн байна. | *2024.06.04-ны өдөр Авилгатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлэг, Авилгын эсрэг нэгдье гэсэн сургалтанд хамрагдаж, Ёс зүйн мэдэгдэлтэй танилцаж, гарын үсэг зурж, баталгаажуулсан.<br>2024.11.19-ний өдөр Баянзүрх дүүргийн цагдаагийн газраас зохион байгуулсан "Залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" сургалтад хамрагдаж авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.30 | |
